

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО

Монгол улсын хөгжлийн банк / МХБ/ нь “Т” ХХК-тай 2015 оны 05 сарын 28-ны өдөр зээлийн гэрээ байгуулж 50,000,000 ам.долларыг, жилийн 8.45 хувийн хүүтэй, 2024 оны 12 сарын 01-нийг хүртэл хугацаатайгаар зээлдүүлэхээр харилцан тохиролцсон байна.

2015 оны 07 сарын 20-ны өдөр “Т” ХХК нь дээрх зээлийн эх үүсвэрийг ашиглан “ЮПГ” ХХК-тай “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан. Тухайн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж “Т” ХХК нь “ЮПГ” ХХК-ийн хувьцааг барьцаалсан. “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн зүгээс барьцааны гэрээнд заасан “ЮПГ” ХХК-ийн хувьцаатай холбоотой шаардах эрхийг “Т” ХХК-д шилжүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлсэн.

Эдгээр барьцааны гэрээ болон мэдэгдлийг үндэслэн “Т” ХХК нь 2015 оны 08 сарын 12-ны өдөр Монгол улсын хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж “Хувьцаа барьцаалах гэрээ”-ний шаардах эрхийг барьцаалсан. Ийнхүү барьцаалахдаа хэрэв зээлийн гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хувьцаатай холбоотой эрх шилжихээр тусгажээ.

Ингээд зээлийн гэрээний үүрэг зөрчигдсөн тул Монгол улсын хөгжлийн банкнаас зээлийн гэрээний үлдэгдэл төлбөрт 100 сая төгрөгийг шаардаж, барьцаа хөрөнгүүдээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Чингэлтэй дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Дээрхийн эсрэг хариуцагч талаас “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь “Т” ХХК болон Монгол улсын хөгжлийн банкны хооронд байгуулагдсан 2015 оны 8 сарын 12-ны өдрийн “Шаардах эрх барьцаалах гэрээ”-г хүчин төгөлдөр бусд тооцуулах сөрөг нэхэмжлэл гаргасан.

Асуулт 1: МХБ-ны нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй эсэхэд эрх зүйн дүгнэлт хийнэ үү.

Асуулт 2: Шүүх сөрөг нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд ямар шийдвэр гаргах вэ?

А. Шалгах үзүүлэлт ба оноо хуваарилалт:

№	Шалгах эрх зүйн зохицуулалт	Дүгнэх оноо
1	Зээлийн гэрээний шаардах эрх /ИХ 451.1/	0-2
2	Барьцааны гэрээнээс гүйцэтгэл явуулахаар шаардах эрх 1. Нэхэмжлэгчид барьцааны эрх үүссэн эсэх: А. Үндсэн шаардлага ба эрхийн барьцаа /ИХ 153-158/, 164, 87.1, 189.1, 164/	0-6
3	Б. Нэхэмжлэгч барьцааны эрхийг шилжүүлж авсан эсэх /ИХ 123.2, 123.6, 56.1.1, 161/	0-4
4	Нэг. Сөрөг нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэх эсэх: I. Үндсэн нэхэмжлэлийг гаргасан байх II. Ижил төрлийн процесс III. Хэргийн харьяалал, бүрдүүлбэр, өөр шүүхийн шийдвэр гараагүй зэрэг бусад урьдчилсан нөхцөл /ИХШХШТХууль/	0-3
5	IV. Нийтлэг урьдчилсан нөхцөлүүд 1. Хэргийн харьяалал 2. ИХШХША-нд оролцох чадвар, чадамж 3. Бусад шаардлага /ИХШХШТХууль/	0-2
6	V. Дотоод холбоос: эрх зүйн ба үйл баримт Дүгнэлт /ИХШХШТХууль/	0-3
	Нийт оноо	20 оноо

Б. Бодлогын дэлгэрэнгүй шийдэл:

Асуулт 1: МХБ-ны нэхэмжлэл үндэслэлтэй эсэхийг шалгая.

Нэхэмжлэлийг ханган шийдвэрлэхийн тулд МХБ нь хариуцагч “ЮПГ” ХХК-ийн эсрэг барьцааны эрхээс гүйцэтгэл явуулах ИХ-ийн §164.1, 158.1-д заасан шаардах эрхтэй байх ёстой.

I. Зээлийн гэрээний шаардах эрх:

Нэхэмжлэгч нь нь “Т” ХХК-тай 2015 оны 05 сарын 28-ны өдөр зээлийн гэрээ байгуулж 50,000,000 ам.долларыг, жилийн 8.45 хувийн хүүтэй, 2024 оны 12 сарын 01-нийг хүртэл хугацаатайгаар зээлдүүлэхээр харилцан тохиролцож, ИХ-ийн §451.1-д заасан зээлийн гэрээг байгуулсан. Талууд зээлийн гэрээний үүрэг хангагдахгүй нөхцөлд барьцаа хөрөнгөөс гүйцэтгэл явуулахаар тохирсон.

II. Барьцааны эрхээс гүйцэтгэл явуулахаар шаардах эрх, ИХ-ийн §164.1, 158.1:

Зээлийн гэрээний хариуцагч нь Т-ХХК байгаа ч нэхэмжлэгч нь “ЮПГ” ХХК-ийн эсрэг барьцааны эрх олж авсан нөхцөлд барьцаагаар хангуулах шаардлага гаргах эрхтэй болно.

1. Барьцааны эрх үүссэн эсэх:

а. Үндсэн шаардлага ба эрхийн барьцаа:

2015 оны 07 сарын 20-ны өдөр “Т” ХХК нь дээрх зээлийн эх үүсвэрийг ашиглан “ЮПГ” ХХК-тай “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-г байгуулж, гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор “Т” ХХК нь “ЮПГ” ХХК-ийн хувьцааг барьцаалсан гэжээ. Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ¹ нь ИХ-д дурдагдаагүй, гэхдээ 2 хувь этгээдийн оролцоо бүхий зээлийн болон хамтран ажиллах төрлийн гэрээний үүргүүдийг зохих хэмжээгээр хослуулсан нэрлэгдээгүй бөгөөд холимог гэрээ юм, ИХ-ийн §189.1.

Барьцааны эрхийн үндэс нь “Т” ХХК-ийн зүгээс хөрөнгө оруулалтаа буцаан шаардах эрх бөгөөд үүнийг “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн /гуравдагч этгээдийн/ хувьцаагаа компаниас шаардах эрхийг барьцаалах гэрээгээр баталгаажуулсан.

Тэгэхээр хувьцаа шаардах эрхийг барьцаалах эрх нь “Т” ХХК-д анхдагч хэлбэрээр үүсжээ.

б. Нэхэмжлэгч барьцааны эрхийг шилжүүлж авсан эсэх:

Нэхэмжлэгч МХБ нь “Т” ХХК-д анхдагч хэлбэрээр үүссэн барьцааны эрхийг хожим шилжүүлэн авсан эсэхийг шалгана. Барьцаалагч шаардах эрхээ шилжүүлэхэд ИХ-ийн §123-ыг баримтлана. ИХ-ийн §123.2.-ын дагуу шаардах эрх эзэмшигч нь гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр шаардах эрхээ шилжүүлж болох ба §123.6.-д шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлснээр түүнтэй холбоотой бусад эрх болон түүнийг хангах арга нэгэн зэрэг шилжинэ.

“Т” ХХК нь 2015 оны 08 сарын 12-ны өдөр Монгол улсын хөгжлийн банктэй байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж, “ЮПГ” ХХК-ийн эсрэг түүний хувьцаа эзэмшигчийн “Хувьцаа барьцаалах гэрээ”-ний шаардах эрхийг МХБ-нд барьцаалах тухай 2015 оны 12-ны өдрийн “Шаардах эрх барьцаалах гэрээ”-г байгуулсан.

Ийнхүү барьцаалахдаа “Т” ХХК бусдын өмнө зээлийн гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хувьцаатай холбоотой эрх шилжихээр тусгасан заалт нь нэхэмжлэгч МХБ-нд уг эрхийн барьцаагаар хангуулах эрх шилжсэн эсэх нь эргэлзээтэй байна. Тиймээс энд гэрээг тайлбарлах тухай ИХ-ийн §198.5-ын дагуу талуудын хүсэл зоригийг тайлбарлах ба үүний сацуу ИХ-ийн §123.6.-д заасан

¹ 2014 оны 2 сарын 21-ний өдрийн Засгийн газрын 52 дугаар тоот тогтоолоор Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмыг баталсан боловч энд хөрөнгө оруулалтын гэрээ нь яг мар төрлийн гэрээ болохыг тухайлан заагаагүй. – Э.Байгал: Олон улсын хөрөнгө оруулалтын арбитр, 2022 он, 107/ 110 дахь тал.

шаардах эрхийг шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх гэдэгт нийцэх гэрээг МХБ байгуулж чадсан эсэхийг тодруулах шаардлагатай.

ИХ-ийн §155.1.-д заасны дагуу үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдсан шаардлагыг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд барьцааны эрх шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжих тухай зохицуулалт нь мөн ИХ-ийн §161.1.-д үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх замаар барьцааны эрхээ бусдад шилжүүлж болно хэмээн тусгалаа олжээ. Эдгээр зохицуулалт нь барьцаагаар хангагдсан үндсэн шаардах эрх өөр этгээдэд шилжихэд барьцааны эрх нь уг үндсэн шаардах эрхтэй хамт шилжих дагалдах эрх болохыг тодотгосон агуулгатай.

Өөрөөр хэлбэл ИХ-ийн §161.1-д заасанчлан үүргийн гүйцэтгэлийг хангах арга болох барьцааны эрх нь үндсэн шаардлагаас тусдаа шилжих боломжгүй байхаар зохицуулсан, барьцааны эрх нь үндсэн үүргийг баталгаажуулах зорилго бүхий дагалдах эрх бөгөөд үндсэн шаардах эрхгүйгээр барьцааны эрх нь үүсэж, оршин тогтнож, бусдад шилжих боломжгүй. Тиймдээ ч тухайн салгаж үл болох эрхийг дангаар шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцэл нь хууль зүйн хүчин төгөлдөр бус байх ёстой, ИХ-ийн 56.1.1.

Энэ маргааны хүрээнд “үндсэн шаардлага +барьцааны эрх” гэсэн ойлголтуудын зэрэгцээ хувьцаа шаардах эрхийг барьцаалж, түүнийг шилжүүлж байгаа нь маргаан үүсгэх хүчин зүйл болсон. Тухайлбал “Т”ХХК-ийн зүгээс “ЮПГ”ХХК-тай байгуулсан “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-ээс үүдэлтэй хөрөнгө оруулалтаа буцаан шаардах эрх нь МУ-ын Хөгжлийн банканд шилжээгүй, харин хувьцаа барьцаалах эрх энэхүү үндсэн шаардлагаас тусдаа гэхдээ хувьцааг компаниас гаргуулах хувьцаа эзэмшигчийн шаардах эрхийн хамт шилжсэн байх магадлалтай.

Хөгжлийн банк зээл олгохдоо хөрөнгө оруулалтын гэрээний буцаан шаардах эрхийг (шаардах эрх №1) шилжүүлж аваагүй, гагцхүү “ЮПГ”ХХК-ийн хувьцааг барьцаалах эрхийг (шаардах эрх №2) л зээлийн гүйцэтгэлийн барьцаа болгон шилжүүлж авах тухай заасан. Анхан шатны шүүх барьцааны эрх шилжихийн тулд ИХ-ийн §161.1-д заасан “үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх замаар барьцааны эрхээ бусдад шилжүүлж болно” гэдгийг явцуу хүрээнд барьцааны зүйл болж буй хувьцаа шаардах эрх биш, харин түүнийг барьцаалах болсон шалтгаан буюу хөрөнгө оруулалтын гэрээний шаардлага шилжих замаар шилжих ёстой гэж тайлбарласан.

Дээрх тохиолдолд хөрөнгө оруулалтын гэрээний шаардлага нь барьцааны эрхтэй салшгүй холбоотой үндсэн шаардлага бөгөөд “ЮПГ”ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хувьцаа шаардах эрхээ барьцаалах гэрээнд тусгагдсан хувьцааг шаардах эрх, барьцааны эрх гэсэн 2 ойлголтоос ялгагдаж ёстой ажээ.

ИХ-ийн §164 нь эрх барьцаалахад ИХ-ийн §161.1 мөн үйлчлэхээр заасан нь ямар ч барьцааны эрх шаардах эрхийн хамт шилжих акцессор шинж буйг илтгэсэн зарчмын шинжтэй байна. Гэтэл практикт эрх зүйн харилцаанд оролцогч аж ахуйн нэгж, банк хүртэл энэ зохицуулалтыг буруу хэрэглэж, хувьцаа эзэмшигчийн хувьцаа шаардах эрхийг цуг шилжих үндсэн үүрэг хэмээн ойлгон тайлбарлаж, барьцааны эрхийг түүнтэй хамт шилжүүлэн авахаар гэрээ байгуулсны улмаас хожим Хөгжлийн

банк өгсөн зээлийнхээ үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслийг алдаж байгаа сөрөг үзэгдлийг өгөгдлөөс харж байна боломжтой.

Шүүх “ЮПГ” ХХК болон “ТОСК” ХХК-ийн хооронд 2015 оны 07 сарын 20-нд байгуулсан “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-нд заасан “ТОСК” ХХК-ийн шаардах эрхүүд нэхэмжлэгч Монгол улсын хөгжлийн банканд шилжсэн гэж үзэх үйл баримт хэргийн өгөгдөлд байхгүй тул “ЮПГ” ХХК болон “ТОСК” ХХК-ийн хооронд 2015 оны 07 сарын 20-нд байгуулсан “Хөрөнгө оруулалт, санхүүжилт хийх хамтран ажиллах гэрээ”-ний шаардах эрх, үүрэг нь хариуцагч буюу МХБ-д шилжээгүй, ийм байхад уг гэрээний үүргийг хангах зорилготой барьцааны эрхийг шилжүүлэх боломжгүй гэж үзэхээр байна².

Дүгнэлт. Тиймээс шүүх МХБ-ны эрхийн барьцаанаас зээлийн үүргийг гүйцэтгүүлэхийг шаардсан нэхэмжлэлийг хангахгүй, хэрэгсэхгүй болгон шийдвэрлэнэ.

Асуулт 2: Шүүх сөрөг нэхэмжлэлийн шаардлагаар иргэний хэрэг үүсгэх эсэхийг тодруулая.

А. Сөрөг нэхэмжлэлийг шүүх хүлээн авах эсэх:

“ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь сөрөг нэхэмжлэл гаргаж буй бөгөөд “Т” ХХК болон МХХБ хооронд байгуулагдсан 2015 оны 12-ны өдрийн “Шаардах эрх барьцаалах гэрээ”-г хүчин төгөлдөр бусд тооцуулах шаардлага гаргасан. Энэхүү сөрөг нэхэмжлэлийг шүүх ИХШХША-г эхлүүлэх ерөнхий ба тусгай нөхцөлүүд хангагдсан тохиолдолд хүлээн авч шийднэ.

I. Үндсэн нэхэмжлэл гаргасан байх:

Сөрөг нэхэмжлэл гаргахыг тулд эхлээд үндсэн нэхэмжлэл гаргасан, шүүх түүнийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн байх ёстой. Гэтэл энэ тохиолдолд МХБ-ны ЮПГ-ХХК-ийн эсрэг гаргасан нэхэмжлэлээр ИХШХША эхлүүлсэн.

“ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн сөрөг нэхэмжлэлийг зохигч ижил байх шаардлагын хүрээнд авч үзнэ.

II. Үндсэн ба сөрөг нэхэмжлэлийн процесс ажиллагаа ижил байх:

Үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг ижил төрлийн процесс ажиллагааны журмаар шийдвэрлэх боломжтой байх ёстой. Эдгээрийн аль алиныг нь ердийн журмаар хянан хэлэлцэж шийдвэрлэхээр байна.

III. Нийтлэг урьдчилсан нөхцөлүүд:

1. Хэргийн харьяалал:

² Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн шүүх энэ маргааныг харьяалан шийдвэрлэх боломжтой эсэхийг шалгая.

а). Шүүхийн харьяалал:

ИХШХШТХ-ийн §19.1-ийн дагуу анхан шатны шүүх энэ хэргийг авч шийдвэрлэнэ.

б). Шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалал:

аа). Онцгой харьяалал: Шүүхийн онцгой харьяаллыг үндэслэх нөхцөл бүрдээгүй.

Мөн гэрээний шаардах эрхийн тусгай харьяаллын маргаан эсэхийг дүгнэхэд өгөгдлийн үйл баримт хангалтгүй байна.

бб). Ерөнхий харьяалал. Шүүхийн ерөнхий харьяаллыг хариуцагчийн оршин суугаа газраар тодорхойлно, ИХШХШТХ-ийн §14. МХБ-ны удирдлага оршин буй газрын талаар өгөгдөлд тодорхой дурдаагүй. Гэхдээ сөрөг нэхэмжлэл гаргах бусад урьдчилсан нөхцөл бүрдсэн бол ИХШХШТХ-ийн §73 нь хариуцагч МХБ-ны оршин буй газраас үл хамаарч Чингэлтэй дүүргийн шүүхийн харьяалаалд хамаатуулан шийдвэрлэх боломжтой.

Тиймээс зөвхөн энэ тохиолдолд гуравдагч этгээдийн сөрөг нэхэмжлэлийг үндсэн шаардлагатай хамт шийдэж болно.

2. ИХШХША-нд оролцох чадвар, чадамж:

Хувьцаа эзэмшигч хувь хүнийхээ хувьд ИХШХША-нд оролцох чадвар, чадамжтай. Харин ЮПГ-ХХК нь ИХ-ийн §26.1 болон КтХ-ийн §83-ын дагуу ИХШХША-ны зохигч байх эрхтэй ба процесст гүйцэтгэх удирдлагаар төлөөлүүлэн оролцоно, КтХ-ийн §83.6.

3. Бусад шаардлага:

Нэхэмжлэлийг хүлээн авахад тавигдах бусад шаардлага хангагдсан. Тухайлбал нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангагдсан ба сөрөг нэхэмжлэгчийн шүүхээр эрхээ хамгаалуулах ашиг сонирхол бий.

IV. Зохигч ижил байх шаардлага:

Үндсэн ба сөрөг нэхэмжлэл гаргаж буй талууд ижил байх ёстой. ИХШХШТХ-ийн §73-т заасны дагуу сөрөг нэхэмжлэл гаргах эрхийг зөвхөн хариуцагч эдлэх бөгөөд үүнийгээ зөвхөн нэхэмжлэгчид холбогдуулан гаргана. Дээрх тохиолдолд үндсэн нэхэмжлэлийн хариуцагч нь “ЮПГ” ХХК бөгөөд үндсэн нэхэмжлэлийн эсрэг **хариуцагч талаас** “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч МХБ-нд хандан сөрөг нэхэмжлэл гаргасан гэсэн өгөгдөл байна.

Энэ тохиолдолд ИХШХШТХ-ийн §73-ын зохигч ижил байх хуулийн шаардлага хангагдсан эсэх нь эргэлзээтэй байна. Өгөгдлийн дагуу үндсэн нэхэмжлэлийн хариуцагчаар “ЮПГ” ХХК өөрөө татагдсан бөгөөд өгөгдлийн “хариуцагч талаас” гэдгийг хувьцаа эзэмшигч хариуцагч байх боломжтой эсэх дээр тайлбар өгнө.

Харин энэ хэргийн шүүхийн шийдвэрийг үзвэл гагцхүү “ЮПГ” ХХК хариуцагчаар татагдсаныг уншиж танилцсан хуульч нь гуравдагч этгээдээр процесст оролцож буй этгээд үндсэн нэхэмжлэгчийн эсрэг сөрөг нэхэмжлэл гаргах боломжтой эсэхийг тайлбарлана.

- Энэ талаарх иргэний шүүхийн байр суурь нь зөвхөн үндсэн нэхэмжлэлийн талууд хоорондоо сөрөг нэхэмжлэлээр холбогдох боломжтой гэж үздэг³.
- Харин зарим судлаач процесст оролцогч гуравдагч этгээд үндсэн нэхэмжлэгчид хамаатуулан уг сөрөг нэхэмжлэлийг гаргасан бол энэ нь ИХШХШТХ-ийн §73-ын хэрэглээнд багтах ёстой гэж үздэг. Сөрөг нэхэмжлэл гаргаж буй этгээд нь энд үндсэн нэхэмжлэгчийн эсрэг дээрх нэхэмжлэлийг гаргаснаар бие даасан нэхэмжлэгчийн байр сууринд очиж эрх үүрэг эдлэх болно. “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь барьцааны үүргийн үүрэг гүйцэтгэгч болох тул энд үндсэн нэхэмжлэлийн хэргийн оролцогч болсон байх магадлалтай. Тиймээс түүнийг бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд хэмээн үзэж сөрөг нэхэмжлэлийг шүүх авч шийдвэрлэх боломжтой.

V. Дотоод холбоос: эрх зүйн ба үйл баримтын?

Сөрөг нэхэмжлэл үндсэн нэхэмжлэлийг үгүйсгээд зогсохгүй түүнээс ялгагдах агуулгатай байх, мөн хамт шийдвэрлэх холбоостой байх шаардлагатай. ИХШХШТХ-ийн §73 нь дээр дурдсанчлан сөрөг нэхэмжлэлийн харьяаллыг үндсэн нэхэмжлэлийн шүүхэд оноохоос гадна тус нэхэмжлэлийг шүүх хүлээн авах урьдчилсан нөхцөл болох эсэх нь онолын хувьд маргаантай.

Зарим улсын шүүх үндсэн ба сөрөг нэхэмжлэлийн дотоод холбоос байх эсэхийг аливаа сөрөг нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзах үндэслэлд хамаатуулан ойлгодог. Сөрөг нэхэмжлэл нь үндсэн нэхэмжлэлтэй эрх зүйн болон эдийн засгийн холбоогүй тул үүнийг шүүх хүлээн авч хамт шийдэхгүй. Үндэслэл нь нэхэмжлэгчийг өөрийн нэхэмжлэлтэй үл хамаарах процессоос хамгаалах шаардлага бий.

ИХШХШТХ-ийн §73-ыг зарим судлаачид гагцхүү сөрөг нэхэмжлэлийн харьяаллыг хамарсан зохицуулалт гэж үзэх ба дотоод холбоос бий эсэх нь зөвхөн харьяалал тогтооход ач холбогдолтой гэдэг. ИХШХШТХ-ийн §73-т үгзүйн тайлбар хийж үзвэл заавал эрх зүйн дотоод холбоо бий нөхцөлд л сөрөг нэхэмжлэл гаргана; бусад тохиолдолд өөр хоорондоо ямар нэг сэжмээр холбогдох нөхцөлд энэ зохицуулалтыг ашиглаж болохгүй гэсэн үг хэллэг алга байна.

Дээрх үзэл баримтлалууд өөр өөр тайлбар дүгнэлтэд хүрч байгаа тул онолын хувьд алиныг дэмжих тухайгаа шүүх илэрхийлэх ёстой. Үндсэндээ сөрөг нэхэмжлэл ба үндсэн нэхэмжлэлийг дотоод холбоо хангалтгүй бол эдгээрийг заавал хамтатган шийдвэрлэх гэхгүй, салгаж болно. ИХШХШТХ-ийн §73.2-ын 2 дахь өгүүлбэрт үнэхээр тооцох түвшинд нягт холбоотой байгаа шаардлагыг хамт шийдээд, бусад тохиолдолд салгах эсэхээ шүүх шийднэ гэсэн байдаг.

Өгөгдлөөс үзвэл “ЮПГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хувьцааг барьцаалсан гэрээг хүчингүй болохыг тогтоолгох шаардлага нь агуулгын хувьд үндсэн

³ Энэ 2 үзэл баримтлалын аль нэгийг үндэслэлтэй толилуулах шаардлагатай бөгөөд аль нэгийг нь сонгосон шалтгаанаар оноог хасан тооцоогүй болно.

шаардлагатай холбоотой, мөн субъектын хувьд өөр этгээд байгаа тул үндсэн шаардлагыг үгүйсгэх хариу эсэргүүцлээс давсан шинжтэй байна.

В. Дүгнэлт:

1-р үзэл баримтлал: Сөрөг нэхэмжлэлийн дагуу иргэний хэрэг үүсгэхгүй.

2-р үзэл баримтлал: Сөрөг нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэх нь процесс хэмнэх зорилго бүхий ИХШХШТХ-ийн §73-ын зорилго зорилтод нийцэж байна.